

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.05.02

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 05 сарын 02


Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,084	0.588%	8.249%	8.210%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.588 хувиар чангарлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахаар Төв банкнаас интервенцийг нэмэгдүүлж байгаа ч эрэлт өндөр байгаа тул ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарсаар байна.

Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 166.5 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкууд 2 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн форвард хэлцэл байгуулах саналыг хоёр удаа, 10 сая ам.доллартай тэнцэх своп хэлцэл байгуулах саналыг ирүүлсэн ч Монголбанкнаас биелүүлээгүй байна.



Гадаад худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар нүүрсний импортын тарифаа түр хугацаанд цуцалж байгаагаа мэдэгдлээ. БНХАУ-ын засгийн газар дотооддоо нүүрсний үнийг барих нүүрсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс тус арга хэмжээг авч байгаа бөгөөд энэ нь Монгол Улстай адил нүүрс экспортлогч орнуудад эерэг мэдээлэл болж байна.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 5 сарын 2

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	103.315	1.52%	2.82%	13.62%
EURUSD	1.0528	-0.12%	-4.75%	-12.71%
USDCNY	6.6076	0.76%	3.87%	2.09%
USD RUB	70.96	-2.96%	-15.47%	-5.65%
USD JPY	130.07	1.84%	6.23%	19.39%
AUDUSD	0.7060	-0.11%	-1.69%	-9.08%

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэргийн чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Энэ 7 хоногийн лхагваас пүрэв гарагт шилжих шөнийн 02:00 цагт АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн нээлттэй захын хурал болж бодлогын хүүгийн шийдвэрээ гаргана.
- ХНС-ийн тэргүүн Jerome Powell болон зөвлөлийн гишүүд бодлогын хүүгээ 50 нэгжээр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн.
- ХНС-ийн балансыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд тус арга хэмжээгээр сард 120 тэрбум ам.долларын үнийн дүн бүхий бондыг зах зээлд нийлүүлэх төлөвтэй байна.
- Бодлогын хүүгийн эрчимтэй өсөлт болон ХНС-ийн балансын бууралт зэрэг нь ам.долларын бусад валютуудын эсрэг хүчтэй чангарах үндсэн суурь хүчин зүйл болоод байна.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 2/May/2022 - 132.44 GMT. Powered by TradingView.
US Dollar Index Futures, (CFD):DX, D



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.